



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

- [f facebook.com/Rtcc.m0n](https://www.facebook.com/Rtcc.m0n)
- <http://rtcc.mrtd.gov.mn>
- info@rtcc.mrtd.gov.mn
- +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2020 оны 04 дүгээр сарын дугаар



"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу 2020 оны 03 дугаар сарын төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогыг хэрэгжүүлэх газар, Бодлого төлөвлөлтийн газарт хүргэж танилцуулсан.

2020 оны 03 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtcc.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.



Хөдлөх бүрэлдэхүүнийг бодит цагаар тодорхойлох систем, галт тэрэг найруулах, сэлгэх ажлыг цахимаар төлөвлөх, үйл ажиллагааг автоматжуулах, нэвтрүүлэх системүүдийг турших бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Цахим худалдаа одоо байгаа хурдаараа өсөн нэмэгдвэл 2021 он гэхэд цахим худалдан авагчдын тоо дэлхийн нийт хүн амын 3/1-тэй тэнцэх хэмжээнд буюу 2.14 тэрбум болно гэсэн судалгаа байдаг. Иймээс энэхүү өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахын тулд тээвэр логистикийн салбарт олон тооны технологийн болон удирдлага зохион байгуулалтын шинэ шинэ шийдлүүд шаардагдаж, бүтээгдэхүүн үйлчилгээнүүд нарийн төрөлжиж байна. Үүний нэг нь төмөр замын салбарт БНХАУ-ын Харбины төмөр замын судалгааны институттай хамтран хөдлөх бүрэлдэхүүнийг бодит цагаар тодорхойлох систем, галт тэрэг найруулах, сэлгэх ажлыг цахимаар төлөвлөх, үйл ажиллагааг автоматжуулах, нэвтрүүлэх системүүдийг турших бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Туршилтын хүрээнд “МТЗ” ТӨХК-ийн өртөөнд хөдлөх бүрэлдэхүүнийг бодит цагаар тодорхойлох систем, галт тэрэг найруулах, сэлгэх ажлыг цахимаар төлөвлөх, үйл ажиллагааг автоматжуулах, нэвтрүүлэх, системүүдийг жижгэрүүлсэн хувилбараар хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Мөн Зам тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлд танилцуулж, төслийг үнэлэх, дүгнэх, хэрэгцээ шаардлагыг нь тодорхойлох, туршилтын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг дурдах нь зүйтэй юм.



Төвийн албан хэргийн хүрээнд авч хэрэгжүүлж буй ажлууд

Зам, тээврийн салбарын хэмжээнд 2020 оныг “Сахилга хариуцлага-Хөдөлмөрийн аюулгүй байдлын жил” болгон зарласантай холбогдуулан ажилтнуудын ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа үр дүнтэй гүйцэтгэх, дотоод журмыг чанд сахиж буйд хяналт тавьж, үр дүнг тооцох, илэрсэн алдаа, дутагдлыг засч залруулах, ажил сайжруулж сахилга хариуцлага, дэг журмыг бэхжүүлэх зорилгоор холбогдох удирдамжийн хүрээнд дотоодын хяналт, үзлэгийг зохион байгууллаа.



Зам, тээврийн хөгжлийн яамнаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хүрээнд “ГТХЗНТ” УТУГ-ын 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд захирлын А/24 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулав.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2019 оны үйл ажиллагааны тайлан хамгаалалтын үед гарсан саналыг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ГТХЗНТ-ийн хариуцан хэрэгжүүлэх 21 арга хэмжээний хэрэгжилтийн байдал, биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнав.



ХАБЭА-н ажлын хүрээнд:



04 дүгээр сарын 23-ны өдөр Зам, тээврийн салбарын ХАБЭА-н салбар хорооноос зохион байгуулсан ХАБЭА-н 3 шатны хяналтын үзлэгийг зохион байгуулах талаарх сургалт, мэдээллийн арга хэмжээнд ХАБЭА-н ажилтан, инженерүүд хамрагдлаа. Тус сургалтаар ХАБЭА-н бодлого, хэрэгжилтийг хангуулах, 3 шатны үзлэгийг зохион байгуулах талаар салбарын ХАБЭА-н ажилтан, инженерүүд санал бодлоо солилцон, нэгдсэн ойлголтод хүрч, туршлага судаллаа.



Зам, тээврийн мэргэжлийн боловсрол сургалтын төмөр замын дэд салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд орж хамтран ажиллаж байна.




“ГТХЗНТ” УТУГ нь Зам, тээврийн мэргэжлийн боловсрол, сургалтын салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн тогтоолоор Зам, тээврийн мэргэжлийн боловсрол сургалтын төмөр замын дэд салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд орж хамтран ажиллаж байна.

Монгол Улсын хэмжээнд олон төмөр замууд бий болж шинэ техник, технологи, үйлчилгээ эрчимтэй нэвтэрч, үүнийг даган шинэ мэргэжлүүд гарч байгаатай холбоотойгоор “Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08”-д нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага бий болж байна.




Зам, тээврийн мэргэжлийн боловсрол сургалтын төмөр замын дэд салбар зөвлөлийн гишүүд нь “УБТЗ” ХНН-ийн одоо байгаа ажил мэргэжлийн жагсаалтыг гаргаж, Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д нийцүүлэн ажил мэргэжлийг кодчлох, орхигдсон ажил мэргэжлийг нэмж оруулах, шинээр үндэсний код үүсгэх ажлыг эхлүүлэн ажиллаж байна.



Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас баталсан Ажил, мэргэжлийн Стандарт Ангилал (ISCO-08)-ын үзэл баримтлал, суурь зарчим, бүтцийг авч боловсруулсан манай улсын “YAMAT-08” нь 10 үндсэн бүлэгтэй, тэдгээр нь 43 дэд бүлэг, 153 бага бүлэг, 421 нэгж бүлгээс бүрдэх шаталсан бүтэцтэй юм. Энэхүү ажил, мэргэжлийн ангиллыг хөдөлмөрийн зах зээл, цалин хөлсний судалгаа шинжилгээ хийх, боловсролын болон хүний нөөцийн хэрэгцээг судлах, тооцох, төлөвлөх, хүн амын хөдөлмөр эрхлэлт ба ажилгүй хүнийг ажил мэргэжил бүрээр бүртгэх, ажилд зуучлах, ажил, мэргэжлээр ангилсан мэдээллийг цуглуулах, боловсруулах, олон улстай харьцуулах, сургалтын үйл ажиллагаа эрхлэх, байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаанд хэрэглэх, ажлын байрны үнэлгээ хийх зэрэгт хэрэглэж байна.

Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




Зорчигч тээвэрлэлт 2020 оны гуравдугаар сард 101.1 мян.зорчигч тээвэрлэсэн, ачаа тээвэрлэлт нь энэ сарын байдлаар 2356.1 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



Дамжин өнгөрсөн ачаа 2020 оны гуравдугаар сард 291.2 мян.тн ачсан байна.

Ачилт- ачааны төрлөөр /2020 оны 3 дугаар сард/






Ачилтаар 2020 оны гуравдугаар сард нүүрс, төмрийн хүдэр, зэс, молибдений баяжмал өссөн үзүүлэлттэй байна. Нийт 5637.1 мян.тн ачсан байна.

Нүүрс	43%
Төмрийн хүдэр	38%
Бусад ачаа	11%
Барилгын материал	2%
Жонш	2%
Зэс, молибдений баяжмал	3%
Нефтийн бүтээгдэхүүн	1%

2020 оны 3 дугаар сард өссөн дүнгээр зорчигч тээвэрлэлт 446.97 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс -20.9%-аар буурсан, ачаа тээвэрлэлт нь 7089.41 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 7.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.



ИНФОГРАФИК





Суурь бүтцийн 2020 оны 3-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

2020 оны 3-р сард нийтдээ 109 удаагийн зурмагын тасалдал бүртгэгдсэнээс:



Зүтгүүрийн албаны 2020 оны 3-р сарын тасалдалыг өмнөх сарын үзүүлэлттэй харьцуулахад энэ сард 1 нэгж буюу 0.91% -иар өссөн байна.



Зорчигчийн галт тэрэгний явуулалтаар нийтдээ 9 тасалдал бүртгэгдсэнээс **Сүхбаатар өртөөнд 6**, **Улаанбаатар өртөөнд 2**, **Дархан өртөөнд 1** удаагийн тасалдал бүртгэгдсэн байна.



Зорчигчийн галт тэрэгний явуулалт 3 сар.				
Д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		Төлөвлөсөн	Биелэлт	Тасалдсан
1	Сүхбаатар	58	52	6
2	Дархан	92	91	1
3	Шарын гол	44	44	0
4	Эрдэнэт	22	22	0
5	Зуунхараа	24	24	0
6	Улаанбаатар	132	130	2
7	Айраг	6	6	0
8	Бор-Өндөр	6	6	0
9	Сайншанд	14	14	0
10	Замын-Үүд	22	22	0
Бүгд		420	411	9

Зорчигчийн галт тэрэгний явуулалтыг өмнөх сартай харьцуулахад тасалдалын тоо 3 нэгж буюу 33,33% -иар өссөн байна.



Суурь бүтцийн 2020 оны 3-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлтээр нийтдээ 12 тасалдал бүртгэгдсэнээс **Сүхбаатар-Улаанбаатар хэсэгт 5, Дархан-Улаанбаатар хэсэгт 2, Дархан-Эрдэнэт хэсэгт 1, Улаанбаатар-Сайншанд хэсэгт 1, Улаанбаатар-Замын Үүд хэсэгт 3** удаагийн тасалдал бүртгэгдсэн байна.

Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлт 3 сар.

Д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		Төлөвлөсөн	Биелэлт	Тасалдсан
1	СБ-УБ	101	96	5
2	Дрх-УБ	50	48	2
3	Дрх-ШГ	89	89	0
4	Дрх-Эрд	44	43	1
5	ЗХ-УБ	44	44	0
6	Айр-БӨ	12	12	0
7	УБ-СШ	28	27	1
8	УБ-Зүүд	44	41	3
	Бүгд	412	400	12

Тасалдлын хэмжээ, тоо




Ачааны галт тэрэгний явуулалтаар нийтдээ 9 тасалдал бүртгэгдсэнээс Сүхбаатар өртөө 1, Дархан өртөө 1, Багахангай өртөө 1, Сайншанд өртөө 5, Замын-Үүд өртөөнд 1 удаагийн тасалдал бүртгэгдсэн байна.

Тасалдлын хэмжээ, тоо




д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		Төлөвлөсөн	Биелэлт	Тасалдсан
2	Сүхбаатар	266	264	0
3	Дархан	98	97	1
4	Дархан-2	167	167	0
5	Шарын гол	50	50	0
6	Салхит	138	138	0
7	Хөтөл	39	39	0
8	Эрдэнэт	53	53	0
9	Зуунхараа	537	537	0
10	Толгойт	286	286	0
11	Улаанбаатар-1	122	122	0
12	Улаанбаатар-2	271	271	0
13	Амгалан	33	33	0
14	Багахангай	28	27	1
15	Мааньт	12	12	0
16	Багануур	97	97	0
17	Чойр	611	611	0
18	Шивээ-овоо	121	121	0
19	Олон-овоо	93	93	0
20	Айраг	124	124	0
21	Бор-өндөр	49	49	0
22	Өргөн	22	22	0
23	Зуунбаян	24	24	0
24	Улаан Уул	26	26	0
25	Сайншанд	757	752	5
26	Замын-Үүд	727	726	1
	Бүгд	4802	4793	9

Ачааны явуулалт, өртөөдөөр






Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлтээр нийтдээ 79 тасалдал бүртгэгдсэнээс Сайншанд-Замын Үүд хэсэг 7, Улаанбаатар-Чойр хэсэг 23, Зүүнхараа-Улаанбаатар хэсэг 16, Чойр-Сайншанд хэсэг 14, Улаанбаатар-Багануур хэсэг 5, Сүхбаатар-Зүүнхараа хэсэг 5, Салхит-Эрдэнэт хэсэг 2, Дархан-Зүүнхараа хэсэг 1, Ерөө-Зүүнхараа хэсэгт 2 удаагийн тасалдал тус тус бүртгэгдсэн байна.



Зүтгүүртэй холбоотой 66 тасалдал гарсан бөгөөд нийт тасалдлын 60,55%-г эзэлж байна. Графикаас харахад 2ТЭ116УМ серийн зүтгүүр нь хамгийн их буюу 37 тасалдал (56,06%), 2ЗАГАЛ серийн зүтгүүр 9 тасалдал (13,63%), 2 ТЭ-116 болон 2ТЭ116УД серийн зүтгүүрүүд нь тус тус 7 тасалдал (10,06%) буюу хамгийн бага тасалдлыг эзэлж байна.



Мөн технологийн зөрчил 5 тасалдал (4,58%), Covid19-тэй холбоотой гааль, мэрэгжилийн хяналт үзлэг хийж тасалдал үүсгэсэн 9 тасалдал(8,25%), галт тэрэгний зам дээр хүн, амьтан, машин яван саад болсон эсхүл дайрагдсан 11 тасалдал (10,09%), мөн БАБС буюу Бүхээгний аюулгүй байдлын системээс шалтгаалсан 8 (7,34%) тасалдал бүртгэгдсэн байна.

Зурмагын биелэлт ерөнхий дүнгээр 2020 оны 3-р сард 5222 галт тэрэг явуулахаас 5204 галт тэрэг явуулж 99,65%-ийн биелэлттэй байна.



Төвийн нийт ажилтан, албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, эрх зүйн аливаа маргаанаас урьдчилан сэргийлэх, тогтмол мэдээ мэдээллээр хангах үүднээс сар болгон хууль сурталчлан таниулах сургалт арга хэмжээ зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд 04 дүгээр сард “Төрийн албаны тухай хууль”-ийн сургалтад нийт ажилтан, албан хаагчид хамрагдсан.





БНТУ: Турк улс Европын холбооны дэмжлэгтэйгээр Стамбул, Болгартай хиллэдэг төмөр замын шугамыг шинэчлэж байна.

200 км урттай гол шугамын энэ хэсгийг шинэчлэн сэргээх ажлыг орон нутгийн барилга угсралтын ажил гүйцэтгэгч байгууллагуудын консорциум гүйцэтгэнэ. Одоо байгаа дэд бүтцийг сайжруулж хоёр замтай шугамыг барьж, 25 кВ-ыг 50 Гц-ын давтамжаар цахилгаанжуулах шаардлагатай байна. Энэхүү шугам нь Европын галт тэрэгний хяналтын систем ETCS 1-р түвшинг багтаасан орчин үеийн харилцаа холбоо, дохиоллын хэрэгслээр тоноглогдоно. Гэрээнд Черкезки, Капикуле өртөөнүүдийг сэргээн засварлах, хэд хэдэн оффисын барилга нэмж барих, хоёр урсгалтай хурдны зам, хэд хэдэн өндөрлөг болон газар доор гарц барих, ус дамжуулах шугам хоолой, бэхэлгээний хана барих зэрэг ажлыг багтаасан байна.



БНСУ- Солонгос улсын төмөр зам арилжааны зориулалтаар шинэ галт тэрэгнүүдийг ашиглалтад оруулна.

Кораил оператор нь 2016 онд Өмнөд Солонгосын “Hyundai Rotem” компанид 250 цувралын зургаан вагонтой 19-н цахилгаан галт тэрэг захиалж байсан (EMU-250). Эдгээр нь NEMU-430C галт тэрэг дээр суурилсан бөгөөд дунд хурдны шугамд ажиллах зориулалттай.



Экспресс галт тэрэгний хамгийн дээд хурд нь 260 км/цаг хүртэл, 380 зорчигч хүчин чадалтай. “Hyundai Rotem” компанид 320 км/цаг хурдтай, 515 хүний суудалтай найман вагонтой хоёр галт тэрэг захиалав. Тэднийг Сөүл-Бусан, Сөүл-Гванжу-Сонжон чиглэлд ашиглахаар төлөвлөж байна.





ХБНГУ: 2.7 сая хүн амтай хотын захын хороолол ба нийслэл Баден-Вуртенбергийг хамарсан Штутгарт мужид Штутгарт 21 төсөл хэрэгжиж байна.



Штутгарт хотын төв хэсэгт байрлах S-Bahn төмөр замын сүлжээг томоохон хэмжээний зохион байгуулалтад оруулах энэхүү төсөл нь нийслэл болон захын хорооллын зорчигчдын урсгал нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Нийт 83 өртөөтэй 200 гаруй км урт долоон шугамыг багтаасан төмөр замын сүлжээ нь өнөөдөр 420 мянган тонн хүртэлх ачаа тээвэрлэлт хийж байгаа бөгөөд зорчигчдын урсгал нэмэгдсээр байна. Долоон чиглэлийн галт тэргийг өнгөрөөдөг ерөнхий хэсэг нь засварлахад хамгийн төвөгтэй хэсэг юм.



Энэ хэсэгт галт тэргэний ачаалал хамгийн өндөр бөгөөд аливаа алдаа нь бүхэл бүтэн S-Bahn сүлжээний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. Төмөр замын дижитал автоматжуулалтын системийг ашигласнаар даацыг нэмэгдүүлж, хөдөлгөөний тогтвортой байдлыг хангахаар төлөвлөж байна. Хотын төмөр замыг GoA2 автоматжуулалтын систем ба дижитал төвлөрүүлэлтийг нэвтрүүлэх, Европын галт тэргэний хяналтын систем ETCS-ийн 2-р түвшний системээр тоноглохоор төлөвлөж байна. Цаашид ETCS 2-р түвшинг нэвтрүүлэх ажлыг хоттой зэргэлдээ газруудад хийхээр төлөвлөж байна. Тооцооллын дагуу нэмэлт зам барихгүйгээр S-Bahn-ийн хүчин чадал 20% -иар нэмэгдэнэ гэж төлөвлөж байна. Цаашид шугамын ерөнхий хэсгийг өмнө зүг рүү хэд хэдэн өртөөгөөр сунгахаар төлөвлөж байна.



БНИУ: Итали улсын Тоскани мужийн засгийн газар бүс нутгийн галт тэрэгний давтамжийг 50% -иар нэмэгдүүлэх бодолтой байна.



Флоренцийн бүс нутагт төмөр замын тээврийн үйлчилгээг тогтмол ашиглах зорчигчдын тоо нэмэгдэж байгаатай холбоотой юм. Тоскани хотын хоёр дах том хот Пратотай Постоиа хот ба Флоренс-ын хооронд оргил үедээ 4 хэсэг галт тэрэг аялдаг.

Үүнээс хоёр галт тэрэг Лукка руу, нөгөө нь Виареджо руу явдаг. Санта-Мария-Новелла өртөөнөөс Пиза руу гурван хос галт тэрэг явдаг ба тэдний зарим нь Ливорно боомт хотод хүрдэг.



Эдгээр чиглэлд “Хитачи Раиль Итали” компанийн бүтээсэн хоёр давхар Вивалто галт тэрэгнүүд явдаг. Флоренцын ойролцоох төмөр замын шугамуудын хүчин чадал бараг шавхагдаж байгаа тул бүс нутгийн галт тэрэгний тоо, хөдөлгөөний давтамжийг нэмэгдүүлэх асуудал нь өнөөдөр ч хүндрэлтэй хэвээр байна. Камподи Марте ба Рифредди өртөөний хооронд өндөр хурдны галт тэрэг өнгөрөх туннелийг барьж байгаа бөгөөд ашиглалтад орсны дараа өндөр хурдны болон ердийн галт тэрэгнүүдийг тусад нь салгахад хөдөлгөөний давтамж болон галт тэрэгтний тоог нэмэгдүүлэхэд тусална. Флоренцад Европын галт тэрэгний хяналтын системийн 2-р түвшнийг нэвтрүүлэх явдал нь хатуу шийдвэр юм.





БНФУ: Филиппин улсын төмөр замууд 2017-2022 оны дэд бүтцийн төлөвлөгөөний нэг хэсэг болох Лузон арал дээр томоохон төслийг хэрэгжүүлж байна.

Хойд-Өмнөд төмөр замын төсөл нь арал дээрх төмөр замын ачааллыг сэргээхэд чиглэсэн бөгөөд тээвэрлэлт, ложистикийн үйлчилгээг сайжруулах замаар Манила ба нийслэл Албай мужийн Легазпи-ийн эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой юм.



Хотын захад 56 км урттай, 581 км урттай хотын хоорондын шугам сүлжээг бий болгохоор төлөвлөж байна. Энэ шугам нь Манила хотоос өмнө зүгт орших Каламба хот хүртэл, цаашдаа Батангас хүрэх зорилготой. Хотын захын шугамыг Легазпигаас Сорсогон мужийн Матног хүртэл сунгаж байна.



Лузон арлын төмөр замын дэд бүтцийг хөгжүүлэх төслийг Тээврийн газар, Филиппиний үндэсний төмөр зам хамтран Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна.



АХУ: Австрали улсын Викториа мужийн засгийн газар хуванцар хаягдлаар хийсэн дэрийг туршихад зориулж буцалтгүй тусламж олгосон байна.



Эхний 200 дэрийг Дуратраккийг Мельбурн дахь Ричмонд өртөөнд туршсан. Тэдгээрийг полистирол ба хөдөө аж ахуйн хог хаягдлын холимгийг дахин боловсруулсан хуванцраар хийсэн байна. Ийм дэрийг хийхэд ойролцоогоор 1 км замд 64 тонн орчим хуванцар хаягдал шаардагдана.

Үүний зэрэгцээ, дэр нь ердийн модноос хоёр дахин их үнэтэй байдаг бөгөөд тэдний ашиглалтын хугацаа нь одоогийн ашиглагдаж байгаа дэрнээс мэдэгдэхүйц 50 жилээр илүү байна гэсэн тооцоо гаргасан.

Дахин боловсруулсан хуванцар дэрийг үйлдвэрлэх технологийг Монтегийн их сургуультай хамтран “Integrated Recycling” компани боловсруулсан. Дэрийг Викториа дахь аялал жуулчлал, музейн төмөр зам дээр ашиглаж байна. Хотын төмөр замын тээвэрт тэдгээрийн ашиглалтын шинж чанарыг үнэлэн, туршилт хийсний дараа тэдгээрийг ашиглахыг шийднэ.





ЮАР: Жилийн өмнө марганцын хүдэртэй хэт урт галт тэрэг Өмнөд Африк руу туршилтын аялал хийсэн.

Хэт урт галт тэрэгний аялал нь төмөр замын ачаа тээврийн оператор “Трансет Фрейхт Раиль” компанийн хэрэгжүүлж буй 1,067 мм царигтай шугамаар өсөн нэмэгдэж буй марганцын хүдэр тээвэрлэлтийг хөгжүүлэхэд чиглэсэн. 2012-2017 онд Хотазел дахь уурхайгаас далайн боомт руу экспортолсон хүдрийн хэмжээ 12.8 сая тонноос хоёр дахин нэмэгдсэн. Ихэвчлэн галт тэрэгнүүд 342 вагоноос бүрддэг. Туршилтын бүрэлдэхүүн 375 вагоноос бүрдсэн байв. Аяллын зорилго нь 22.5 мянган тонн марганцын хүдрийг тогтмол тээвэрлэх хүчин чадалтай, 4 км урт галт тэрэг бүрдүүлэх байв. Ингэснээр боомтоор авто замаар дамжуулж буй 1.2 сая тонн хүдрийг одоо төмөр замаар тээвэрлэх боломжтой болно.




БНГУ: 1067 мм царигийг 1435 мм-ийн болгон өөрчлөх Өстөрийн шугамыг сэргээн босгох томоохон төслийг Гана Европын төмөр замын консорциум хэрэгжүүлнэ.

Консорциумд Гана, Герман, Австри, Франц, Итали улсын хөрөнгө оруулалттай 16 компани багтдаг. Босусогоос Кайе хүртэлх тусгай төмөр замын шугам барихаар төлөвлөж байна. Энэ нь тус бүс нутагт ирээдүйтэй боксит ордыг ашиглах үйлчилгээг үзүүлж, Ашанти хотын ойролцоо байрлах Боанкрагийн хуурай боомттой зүүн шугамыг холбож өгөх юм. Сэргээгдсэн Остерн шугам дээр Аккра, Кофоридуа, Кумаси гэсэн гурван үндсэн өртөө, 30 жижиг өртөө байдаг. Урьдчилан тооцоолсноор ачаа тээврийн жилийн нийт хэмжээ 4 сая тонноор нэмэгдэж, зорчигчдын урсгал 12 мянгаас 18 мянган хүнд хүрнэ. Концессын төсөл нь барилга-ашиглалт-дамжуулах гэсэн зарчим дээр хэрэгждэг. Уг шугамыг Гана Европын төмөр замын консорциум 27 жилийн турш удирдаж, дараа нь Гана улсын засгийн газарт шилжүүлэх юм байна.





 **8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс**

